

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан бөгөөд уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна” гэж заасан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсөвт 2024 оны төвлөрүүлэх орлого, зарлагын бүрэлдэхүүнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар” байгуулах асуудал тусгагдаагүй болно.

Үүнтэй уялдуудан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлд “Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан” болно.

Иймд Төмөр замын тээврийн тухай хуульд хуульчилсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар нь 2024 онд байгуулагдахгүй болсон тул Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн болно.

Хуулийн төслийн зорилго нь Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагаж мөрдөх хугацааг өөрчлөхтэй холбоотой болно.

Хуулийн төсөл нь Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үйлчлэх хугацааг өөрчлөх 1 заалттай бөгөөд шинээр нэр томьёо тусгаагүй болно.

Төмөр замын тээврийн тухай хуулийг 2007 оноос өнөөг хүртэл мөрдөж байгаа болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн хуулийн төслийн үзэл баримтлалын хамт боловсруулан, төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авч, Засгийн хуралдаанаар хэлэлцүүлсэн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Төмөр замын тээврийн тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх нөхцөл бүрдэх бөгөөд улмаар улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал шийдвэрлэгдэх юм.

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.